



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#4 (13)

2023 он

IV сар

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

**2023 оны улсын шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний хурал "БОЛОВСРОЛ ДАХЬ ЁС ЗҮЙН АСУУДАЛ, ШИЙДЭЛ" сэдвээр явагдлаа.**



БСҮХ-ээс зохион байгуулдаг 2022-2023 оны хичээлийн жилийн 56 дахь удаагийн эрдэм шинжилгээний хуралд аймаг, дүүрэгтээ шалгарсан 30 илтгэлийг цахимаар амжилттай хэлэлцүүлж, тэргүүн байр 1, дэд байр 2, гутгаар байр 3, тусгай байр 3 илтгэлүүдийг шалгарууллаа.



## ТЭРГҮҮН БАЙР



Багшийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд Soft skills-ийн “Дотоод ур чадваруудаас санал болгох нь”

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн нийгмийн ухааны багш, А.Очирбат, англи хэлний багш О.Баясгалан, газар зүйн багш Б.Пэрэнлэймаа, сэтгэл зүйч Г.Отгонсүрэн



## ДЭД БАЙР

- “Багшийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт ба хүүхдийн эрх, хамгааллын харилцан хамаарал, асуудал-шийдэл” Хөвсгөл аймгийн БШУГ-ын хэлтсийн дарга Я.Дүүрэнбилэг, Дэлгэрмөрөн ЦС-ийн багш Г.Намсрай, Г.Оюунчимэг, Э.Цэрэнжаргал, Б.Оюунчимэг, Г.Наранжаргал
- “Сургуулийн орчин дахь суралцагчдын ёс зүйн зарим асуудлыг “Сайныг дагаж, зөвөөр үлгэрлэе” нөлөөллийн ажлаар шийдвэрлэх нь” Сэлэнгэ аймаг, Мандал сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн биологи, газарзүйн багш Б.Ууганцэцэг, түүх нийгмийн ухааны багш Н.Болормаа, Т.Лхамдэжид, физикийн багш Ш.Наранцацралт, дизайн технологийн багш Р.Ариунболор



## 3-р БАЙР

- “Багш нарын зөөлөн ур чадварыг нэмэгдүүлэх нь” Увс аймгийн 4 дүгээр сургуулийн багш Ц.Энхмөнх
- “Багшийн ёс зүйн үлгэр дуурайл анги хамт олны хандлага, төлөвшилд нөлөөлөх нь” Өмнөговь аймгийн 3 дугаар сургуулийн багш Д.Энхээ, О.Гангамөрөн
- “Багш суралцагчдад эерэг хандлага төлөвшүүлэхэд зөөлөн ур чадвар буюу харилцаа нөлөөлөх нь” Орхон аймгийн 13 дугаар сургуулийн багш Г.Цэвэгжав



## ТУСГАЙ БАЙР

- “Суралцагчдад үгэн харилцааны зөв дадлыг төлөвшүүлэх шаардлага ба шийдвэрлэх боломж” Баянзүрх дүүргийн 48 дугаар сургуулийн түүх, нийгмийн ухааны багш Ч.Баасанжав, Д.Хандсүрэн, С.Баярмаа
- “Удирдах ажилтны ёс зүй нь багшийн ажиллах мотивацид нөлөөлөх нь” Дархан-Уул аймгийн Оюуны ирээдүй ЦС-ийн багш Б.Мөнхжаргал, Л.Ану
- “Цахим орчин дахь сурагчдын ёс зүйд хийсэн судалгаа түүний үр дүн” Хан-Уул дүүргийн 60 дугаар сургуулийн багш Д.Отгонцэцэг тус тус шалгарлаа.

**БСҮХ-ээс “Оны шилдэг илтгэл” шалгаруулах үндэсний эрдэм шинжилгээний хуралд аймагтаа тэргүүлсэн, удаа дараа амжилттай оролцсон багш нараа салбарын шагналаар шагнав.**

ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ “БОЛОВСРОЛЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” хүндэт тэмдгээр

- Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн түүх, нийгмийн ухааны багш Б.Оюунчимэг,
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн түүх, нийгмийн ухааны багш Д.Нарантуяаг,

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ШАГНАЛ “ЖУУХ БИЧИГ”-ээр

- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын багш О.Гангамөрөн,
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн түүх, нийгмийн ухааны багш Д.Батбаатар, түүх, нийгмийн ухааны багш С.Эрдэнэжаргал нарыг шагналаа.

## “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн “Тэгш хамруулах боловсрол” суурь судалгаа эхэллээ

Ерөнхий боловсролын 18 сургуулиас түүвэрлэн, Нийслэлийн СБД-гийн 58, 71 дүгээр сургууль, БЗД-гийн 88 дугаар сургууль, ХУД-гийн 15, 118 дугаар сургууль, Сүхбаатар аймгийн Баруун Урт сумын ЕБ-ын сургууль, Дарьганга, Түмэнцогт сумын ЕБ-ын сургууль, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Баянгол, Цагааннуур сумын ЕБ-ын сургуулиудаас судалгааны мэдээлэл цуглуулаад байна.

### СӨБ-ын "Амьдралын мод" сургалтын хөтөлбөрийг турших судалгаа



Туршилтын 8 цэцэрлэгийн гарааны судалгааны үр дүнг танилцуулах, үйл ажиллагааны явцыг сургалтын чиглэл бүрээр санал бодлоо солилцох ажил Чингэлтэй дүүргийн 33-р цэцэрлэгт зохион байгуулав. Тус үйл ажиллагаанд БШУ-ы сайд Л.Энх-Амгалан, БШУЯ-ы СӨБ-ын хэлтэс, БСҮХ, БҮТ, БЕГ-ын удирдлага, мэргэжилтнүүд болон туршилтын 8 цэцэрлэгийн төлөөлөл оролцлоо.

### ЕБС-ийн математик суралцахуйг дэмжих Eduten платформыг турших судалгаа



Eduten сургалтыг дэмжих платформын бага боловсролын математикийн даалгаврыг хөрвүүлэх, хянах хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 26-нд зохион байгуулж, барианы үнэлгээний сорил, асуулга боловсруулж гарааны үнэлгээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө, санхүүгийн тооцоолол болон туршилтын явцын тайланг БШУЯ-нд танилцуулав.

### Судалгааны үр дүнг танилцуулах, хэлэлцүүлэх ажил хийгдлээ



БСҮХ-ийн ХХСС-ийн эрдэм шинжилгээний ажилтнуудын хувьд 4-р сар нь “Монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгаа” - ны үр дүнг олон нийтэд түгээн танилцуулах ажлын сар байлаа.



Монголын радиогийн “Завгүй өдөр” оройн хөтөлбөрт Монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгааны үр дүнд тулгуурлан хүүхдийн хөгжлийн онцлог, түүнийг дэмжих талаар ярилцлага өглөө.



Отгонтэнгэр их сургуулиас үндэсний хэмжээнд зохион байгуулсан “Хүүхдийн хөгжил-2023” Эрдэм шинжилгээний хуралд “Өсвөр насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн онцлог”, “Өсвөр насны хүүхдийн хөгжилд хичээлээс гадуурх үйл ажиллагааны нөлөө” сэдвээр 2 илтгэл амжилттай хэлэлцүүлээ.

Судалгааны үр дүнд тулгуурлан “Бага ангиас суурь боловсролын түвшинд шилжих үеийн хүүхдийн дасан зохицох чадварыг дэмжих арга зүйн зөвлөмж” - ийг сургууль багш нарт болон эцэг эхэд зориулсан 2 хувилбартайгаар боловсруулж, экспертийн уншилтад өгөөд байна.



Мөн цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар сайжруулахтай холбоотой үндэсний хэмжээнд 29000 эцэг эх, асран хамгаалагчдаас авсан захиалгат судалгааны мэдээллийг боловсруулж, тайлан хүлээлгэж өглөө.

### “Бага боловсролын монгол хэлний сургалтын эхийн сан бүрдүүлэх” төсөл

Бага боловсролын монгол хэлний сургалтад шаардлага, шалгуурт нийцсэн эх зохиолгох ажлын хүрээнд хүүхдийн зохиолчид, ЕБС-ийн багш нар, их дээд сургуулийн мэргэжлийн ангийн оюутнуудад 2023 оны 4 дүгээр сарын 26-нд сургалт зохион байгууллаа. Сургалтад хамрагдсан зохиогчдод бага боловсролын монгол хэлний сургалтын эх зохиох жишиг шаардлага шалгуурыг танилцуулж, эх шинжлэх дадлага ажил хийлгэж, эхийн 115 эхийг тусгай шаардлагын дагуу боловсруулах эхийн захиалга хийгдээд байна.



### “Хос хэлт сургалтын талаар баримтлах чиглэл”-ийн төслийн хэлэлцүүлэг явагдаж байна

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь БШУЯ, Дэлхийн банк хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн дэмжлэгтэйгээр “Судлагдахуун ба хэлийг интеграцчилан суралцахуй (агуулга болон хэлийг интеграцчилан суралцахуй- АХИС)-г туршин нэвтрүүлэх нь” судалгааг зохион байгуулсан байна.



Энэ удаагийн хэлэлцүүлэгт БШУЯ холбогдох мэргэжилтэн, шинжээчдийн төлөөлөл, БЕГ, БҮТ-ийн холбогдох мэргэжилтнүүд болон БСҮХ-ийн ЭША-нууд оролцож байна.

- Хос хэлний боловсрол СХИС арга зүйг туршин нэвтрүүлэх судалгааны үр дүнг танилцуулах
- Хос хэлт сургалтын бодлогын чиглэл (Үндэсний цөөнхийн хүүхдийн хос хэлтсургалтын хүрээнд)-ийн төслийг хэлэлцүүлэх, санал цуглуулах зорилготой.



**“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөл**

ТХБ-II төслийн 2020-2023 оны үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ- II ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ 6 ДУГААР ХУРАЛ БОЛЛОО

Хурлыг Л.Цэдэвсүрэн (БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Төслийн удирдах хорооны дарга) удирдан чиглүүлж, энэхүү үйл ажиллагаанд Швейцарын хөгжлийн агентлагийн Хамтын ажиллагааны газрын дэд дарга Бенуа Меэйр-Биш болон БШУЯ, БОАЖЯ, БЕГ, БСҮХ зэрэг төслийн түшиц байгууллага, төслийн зөвлөн зохицуулах үндэсний багийн гишүүд оролцсон.



“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн зорилтот сургуулиудын хүрсэн үр дүнгээ тооцох, ололт амжилт, туршлага, шинэ санаачилга, бүтээлч арга зүйг олон нийтэд танилцуулан сурталчлах, хуваалцах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Архангай, Булган аймагт БОМСТ, ТЗЗОНБ-тай хамтран зохион байгуулсан мониторинг-үйл ажиллагаанд секторын эрхлэгч Х.Отгонбаатар, эрдэм шинжилгээний ажилтан Ж.Дэнсмаа нар 4 дүгээр сарын 09-19-ний өдрүүдэд ажилласан.

Мониторинг-үйл ажиллагааны хүрээнд “Монгол улсын түвшинд ТХБ-ыг институтчилэх, тогтвортой байдлыг хангах нь” сэдэвт илтгэл танилцуулсан. 2 аймаг, сумын зорилтот сургуулийн баг, ТЗЗОНБ-тай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, оролцогчдыг төслийн үр дүн, өгөөжийн талаар сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан байна.

**БЕГ-ын НТБ-ын хэлтсийн мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгууллаа**

БСҮХ-гийн Боловсролын хөгжлийн ирээдүй судлалын судалгааны секторын ЭША-нууд Насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрийн төсөл боловсруулах арга зүйн ажлын хүрээнд БЕГ-ын НТБ-ын хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрийн талаар мэдээлэл солилцох, цаашид хамтран ажиллах зорилгоор 2023 оны 04 сарын 24-ны өдөр уулзалт зохион байгууллаа. Энэхүү уулзалтаар насанд хүрэгчдийн боловсролыг дэмжих чиглэлээр НТБТ-өөс явуулсан сургалтууд, хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр, НТБ-ын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлж буй байдал, сургалтын хэрэглэгдэхүүний хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнг танилцууллаа.

## Монгол хүүхдийн академик үгийн сангийн нөөцийг тогтоож, үгийн санг түвшинд хуваах судалгааны ажлын хэлэлцүүлгээр БШУ-ны сайд Л.Энх-Амгалан эрдэмтэн, судлаач нартай уулзалт хийлээ

Хэлэлцүүлгийг БШУЯ-н дээр 2023 оны 04 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулав.



“Хүүхдийн академик үгийн нөөцийг тогтоож, үгийн санг түвшинд хуваах” судалгааг товч танилцуулав. Мөн үгийн сангийн А түвшний корпусын шинжилгээний үр дүн, Гадаад хэлний үгсийн сангийн хам сэдэвт шинжилгээ хийсэн үр дүнг хэлэлцэв. Зөвхөн сурах бичгийн үгийн нөөц дээр тулгуурлаж академик үгийн сан тодорхойлох нь тийм ч оновчтой биш ба бусад эх сурвалжуудыг судалж, харьцуулах нь чухал гэж үзлээ.

### Их, дээд сургуулийн “БАГШ, БАГА БОЛОВСРОЛ” жишиг бакалаврын хөтөлбөр

Бага боловсролын багш бэлтгэж буй дотоодын болон гадаадын их сургуулийн хөтөлбөрийн харьцуулсан шинжилгээний дүнд

“Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрийн боловсролын зорилтууд (PEOS), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүд (PLOs), сургалтын арга зүй, багшлах бүрэлдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт зэрэг бүрэлдэхүүн хэсгүүд бүхий жишиг хөтөлбөрийг эцэслэн боловсрууллаа. Үүний үр дүнд:

- Бага боловсролын багш бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрийн судалгаа
- “Багш, бага боловсрол” бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчийн чадамжийн хүрээг тодорхойлох судалгаа
- “Багш, бага боловсрол” бакалаврын сургалтын жишиг хөтөлбөр бэлэн болов.

### Тэгш хамрах сургах сургалтын хөтөлбөр



“Дохионы хэл 1-5 анги” сургалтын жишиг хөтөлбөрийг БШУ-ны сайдын А/157, Эрүүл мэндийн шалтгааны улмаас танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдийн явуулын багшийн “Монгол хэл”, “Нийгэм ахуйн баримжаа” сургалтын жишиг хөтөлбөрийг БШУ-ны сайдын А/158 дугаар тушаалаар тус тус батлуулан, сургалтад хэрэгжүүлэхээр боллоо.

### КIХ зөвлөлийн гишүүдийн хурал



Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн дэргэдэх үндэсний боловсролын тэргүүлэх чиглэл, улс орны болон бүс нутгийн түвшний бодлогын сорилтуудыг тодорхойлоход хувь нэмрээ оруулах, мэдлэг инновац, солилцооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Европ, Ази, Номхон далайн бүсийн ажиллагааг Монгол Улсад чиглүүлэн ажиллах зорилготой КIХ зөвлөлийн гишүүдийн уулзалт 4-р

сарын 14-нд зохион байгуулагдлаа.

Энэхүү уулзалтаар тус зөвлөлийн танилцуулга болон чиг үүрэг, ажлын төлөвлөгөөний талаар хэлэлцлээ. Тус зөвлөл нь 8 гишүүнтэй бөгөөд зөвлөлийн даргаар БСҮХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга С.Санжаабадам, зөвлөлийн гишүүдэд БШУЯ, БЕГ, БҮТ, Монголын суралцахуйн бэрхшээлийн холбоо, Монголын Дауны холбоо, БХАН, “Нүүдлийн байгаль хамгаалал” НҮТББ зэрэг байгууллагын төлөөллүүд багтдаг.

### Боловсролын салбарын багш, ажилтнуудад зориулсан “ENGLISH READING TEACHERS’-2023” хөтөлбөр амжилттай хэрэгжлээ



Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн мөн Монголын хил хязгааргүй уншигчдын холбоо (MERA) болон Xreading.com цахим номын сангийн Монгол дахь төлөөлөгч Lingors боловсролын байгууллага хамтран “АНГЛИАР УНШИГЧ БАГШ” буюу “ENGLISH READING TEACHERS’ - 2023” хөтөлбөрийг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 16-ны хооронд гурван үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж дууслаа.

Унших арга зүйгээр нийт багш нарын болон боловсролын салбарын удирдах ажилтнууд, мэргэжилтнүүд, ажилтнуудын унших, бичих, ярих, сонсох ба хэлний хэрэглээний чадварыг хөгжүүлэх зорилготой тус хөтөлбөрт 8572 оролцогч хамрагдан, 1757 оролцогч 2 сарын хугацаанд англи хэлний түвшингөө ахиулан англиар ном уншин, хувь хүний хөгжлийн сургалтуудад хамрагдлаа.

### Багш нар мэргэжил нэгтнүүдийнхээ мэдлэг ур чадварыг ахиулахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Монгол улсын Засгийн газраас баталсан “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ”-г хэрэгжүүлэх хүрээнд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад зориулсан англи хэлний эрчимжүүлсэн сургалттай “Вэлком”, “Англи хэлний зөвлөгч сурагч” хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна.

“Англи хэлний зөвлөгч сурагч” хөтөлбөрийг Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн Өргөө” сургууль дээр удирдаж буй багш Т.Наранцэцэг “Вэлком”, “Англи хэлний

зөвлөгч сурагч” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж буй бусад англи хэлний багш нартаа мэргэжлийн хөгжлийн дэмжлэг үзүүлэх зорилготой сургалтыг санаачилж удирдсан юм. Тэрбээр 2022 оны БСҮХ, БЕГ, Бритиш сургуультай хамтран зохион байгуулсан англи хэлний сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн оролцогч бөгөөд тус сургалтад хамт суралцсан багш Ч.Хишигжаргал болон бусад мэргэжил нэгтнүүдтэйгээ хамтран цахимаар 4-р сарын 28-ны Баасан гарагт англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг амжилттай зохион байгууллаа.